

02 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

а. ИТХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид энэ сард нэг удаа хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

Төрийн одон медаль тодорхойлогдсон нийт 54 иргэний материалыг мэдээллийн санд орууллаа. Монгол Улсын төрийн дээд одон “Гавъяат багш цол”-оор 1, “Хөдөлмөрийн гавъяанц улаан тугийн одон”-гоор 4, “Цэргийн гавъяаны одон”-гоор 2, “Алтан гадас одон”-гоор 20, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар 26, “Шударга журам медаль”-аар 1 нийт 54 хүний материалыг Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлсэн.

Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа эрхэлж буй компаниудаас орон нутагт төвлөрүүлэх хөрөнгийн асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлүүлж буй нөхцөл байдлын талаар танилцуулга хийгдэж тэргүүлэгчдээс чиглэл өгөв.

Аймгийн өмчийн газраас Үндсэн хөрөнгө худалдах, шилжүүлэх, актлах, хөрөнгө шинээр бүртгэж эзэмшүүлэх, Алтан овооны хөрөнгийг байгууллагууд эзэмшүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Аймгийн ИТХ-ын АТГ-ын эрх бүхий албан тушаалтан Аймгийн ИТХ-ын 33 төлөөлөгч мөн сумдын ИТХ-ын төлөөлөгч, нийт 326 төрийн албан хаагчид болон төлөөлөгчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг 2 сарын 15-наас өмнө гаргаж Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн ажилласан.

Мөн аймгийн ИТХ-ын 2019 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг бичиж Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлээд байна.

Аймгийн ИТХ-ын даргын санаачлагаар Коронавирус буюу “Ковид-19” халдварыг таслан зогсоож эрсдэлт нөхцөл байдлыг даван туулахад эв санаа нэгтэй байгаагаа илэрхийлж БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн ард иргэдэд туслах зорилгоор “Зовох цагт нөхрийн чанар танигдана” нэртэй уриалгыг санаачлан төр хувийн хэвшил болон ард иргэдийн дунд зохион байгуулан хандив цуглуулах ажлыг эхлүүлээд байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс Дэлхийн байгаль хамгаалах сангийн зүүн бүсийн салбартай хамтарсан “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-ийг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор байгуулан Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Хууль зүй дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банктай хэрэгжүүлж буй “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн тус аймаг дахь орон нутгийн зохицуулагчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан материалыг ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

Орон нутгийн BBS телевизтэй 2020 онд хамтран ажиллах гэрээ байгуулж Хуулийн байгууллагуудад нэвтрүүлэг хийх хуваарийг хүргүүлсэн. Мөн орон нутгийн “Сүхбаатар өнгө” сонинтой хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Цагдаагийн газрын Замын цагдаагийн чиглэлээр ажиллах Олон нийтийн цагдаагийн дүрэмт хувцасны зардал болох 1.000.000 /нэг сая / төгрөгийг ГХУС сангаас шийдвэрлэсэн.

Шүүхийн шинжилгээний албанд “Архинд донтох эмгэг” сэдвээр сургалт зохион байгуулахад 700.000 /долоон зуун мянган/ төгрөгийг ГХУС сангаас шийдвэрлэсэн. Улаанбаатар хотод зохион байгуулагдах “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтын төлбөр болох 1.000.000 /нэг сая / төгрөгийг Цагдаагийн газарт шилжүүлэн ажиллаж байна.

б. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Аймгийн Засаг даргын зөвлөл энэ сард 2 удаа хуралдан 5 асуудал хэлэцэн шийдвэрлэлээ.

Аймгийн Онцгой комисс цаг үеийн асуудал, үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан . 3 удаа хуралдаж холбогдох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Монгол Улсын цол хүртээх одон медалиар шагнах журмын дагуу Төрийн дээд одон, медалиар шагнуулахаар тодорхойлогдсон 59 иргэний тодорхойлолт материалыг Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд хэлэлцүүлэхээр дэмжин уламжилсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын санаачилгыг дэмжиж БНХАУ-д 1000 хонь, хөрш зэргэлдээх ӨМӨЗО-ны Шилийн гол аймагт 1000 хонь тус тус хандивлахаар боллоо.

МҮОНТ-ийн “Монгол түмний мэнд” сар шинийн баярт зориулсан нэвтрүүлгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил, шилдэг бизнес эрхлэгчийг танилцуулсан 10 минутын нэвтрүүлэгт аймгийн удирдлагууд болон салбартаа манлайлагч иргэдийн төлөөлөл оролцож нутгийн ард түмэндээ мэндчилгээ дэвшүүлж, өнгөрсөн оны ажлын амжилт, мэдээллийг хуваалцсан.

Засаг дарга, Тамгын газар, хэлтсүүдийн үйл ажиллагаа, цаг үеийн мэдээ мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор “Тамгын газрын цаг” нэвтрүүлгийг тогтмол хийхээр болж, хуваарийг баталсан ба энэ сард хуваарийн дагуу НБХэлтэс болон ХОХБТХ-ийн нэвтрүүлэг орон нутгийн BBS телевизээр цацагдаж иргэд олон нийтийн хүртээл боллоо.

Түүнчлэн орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага болох “Сүхбаатарын өнгө” сонины газартай гэрээ байгуулж хамтран ажиллаж байгаа бөгөөд тус сонины 2 удаагийн дугаарт цаг үеийн шинж чанартай 4 мэдээ мэдээлэл бэлтгэн нийтлүүлээд байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/122 дугаар захирамжаар 99 албан хаагчийн хүсэлтийг шийдвэрлэж зэрэг дэв шинээр олгох болон ахиулах арга хэмжээг авлаа. Мөн 13 сумын Засаг даргын цалинг шинэчлэн тогтоосон байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

Орон нутгийн төсвийн орлого, санхүүжилтийг хууль, журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.

Улсын төсвөөс 2020 оны 2 дугаар сард 2.509.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч орон нутгийн төсөвт 1.044.4 сая төгрөгийн орлого орж, орон нутгийн төсвийн нийт зарлага санхүүжилтанд 3.161.1 сая төгрөгийн санхүүжилт хийгдлээ. Үүнээс сумдад санхүүгийн дэмжилгээр 861.8 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардалд 994.4 сая төгрөг, соёлын шилжүүлгийн байгууллагуудын зарлага санхүүжилтанд 355.9 сая төгрөг, Спорт хорооны зарлага санхүүжилтанд 123.0 сая төгрөг, Засаг даргын нөөц санд 90,0 сая төгрөг, Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 22,0 сая төгрөг, гамшигийн эрсдлийн санд 60,0 сая төгрөг, ОНХСанд 30,0 сая төгрөг, Халамжийн санд 25,6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагуудад 598,4 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Аймгийн хэмжээний нийт 877 Аж ахуйн нэгж байгууллагаас 85.6 хувь буюу 749 байгууллагын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим системд хүлээн авч шалган баталгаажуулсан, мөн нийт 120-иод байгууллагад НББүртгэл, санхүүгийн тайлагналын чиглэлээр заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Аймагт даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа явуулдаг 3 банкны салбар, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа явуулдаг 1 байгууллагын 2019 оны тайланг, орон нутаг дах төлөөлөгчийн ажлын тайланг тус тус Санхүүгийн зохицуулах хороонд гаргаж хүргүүлсэн.

ОНХсан, Засаг дарга, Замын сангийн дансны 2019 оны санхүүгийн тайланг гаргаж Төрийн аудитын байгууллагад аудит хийлгэхээр хүргүүлсэн бөгөөд төсвийн шууд захирагчийн Санхүүгийн тайланг хянан, шалгаж нэгтгэж байна.

Орон нутгийн өмчийн газар: 2020 онд Улсын болон Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Аймгийн Засаг даргын 2020 оны А/87 дугаар захирамжаар шинэчлэн баталсан бөгөөд 2 дугаар сарын байдлаар 14 ажил, бараа, үйлчилгээг tender.gov.mn сайтаар дамжуулан зарласанаас, 1 барааны тендерт шаардлага хангасан оролцогч ирээгүй тул дахин зарласан, 2 барааны тендерийг нээж, үнэлээгээний хороо хуралдаагүй, 10 ажил, бараа, үйлчилгээний тендерийг үнэлсэн байна.

2020 оны 02 дугаар сард аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчээр орон нутгийн өмчит байгууллагуудын үндсэн хөрөнгийг худалдах, актлах, шилжүүлэх, бүртгэж эзэмшүүлэх хөрөнгийн жагсаалтыг батлуулсан бөгөөд үүний дагуу холбодох байгууллагуудад тогтоолыг хүргүүлж хяналт тавин ажиллаж байна. Мөн худалдах

хөрөнгийн жагсаалтыг гарган дуудлага худалгааг 3 сард зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба: Албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Байгаль орчин аялал жуулчлалын газар, Орон нутгийн өмчийн газарт санхүүгийн хяналт шалгалтын хийж гүйцэтгэлээ. Хяналт шалгалтаар санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн 999.2 мянган төгрөгийн 2 акт тогтоож 2 албан шаардлага хүргүүлэв.

Шүүхийн хэрэгт 1 объектод шинжээчээр ажиллаж шинжээчийн дүгнэлтийг холбогдох газарт хүргүүлээ.

Гурав. Хууль эрх зүйн салбарт:

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, босоо удирдлагатай зарим байгууллагууд, сумдын томоохон ойн арга хэмжээний талаарх судалгаа, хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн 2019 оны тайланг гаргаж, АТГ-т хүргүүлээ. Аймгийн хэмжээнд нийт 155 албан тушаалтан ХАСХОМ гаргахаас 100 хувь мэдүүлгээ цахим системд хугацаандаа мэдүүлсэнийг хянаж, хуулийн хугацаанд баталгаажуулсан.

АТГ, ЗГХЭГ-аас ирүүлсэн Зөвлөмж хүргүүлэх тухай албан бичгийг нийт 13 сумдын ЭБАТ, ЗДТГ-ын 6 хэлтсийн даргаар дамжуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, зөвлөмжийн талаар төлөвлөгөө гаргаж ажиллах талаар мэдэгдсэн.

Улаанбаатар хот Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатын шүүх "Макс ойл" ХХК-д холбогдох иргэний хэрэгт шүүх хуралдаан хойшлуулах, Сүхбаатар аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх 3.Сумьяагийн нэхэмжлэлтэй хэрэгт шүүх хуралдаан хойшлуулах, гуравдагч этгээд татан оролцуулах хүсэлт гарган хүргэж өгсөн.

Сүхбаатар аймаг дахь сумд дундын иргэний хэргийн анхан шатны шүүх Ч.Энхцэцэгийн нэхэмжлэлтэй хэрэгт хариу тайлбар гарган, итгэмжлэгдсэн төлөөлөгч томилогдон, өмгөөлөгч Ж.Цээсүрэнгийн хамт 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдөр болсон шүүх хурал оролцов. Шүүх хурлаас нэхэмжлэгч Ч.Энхцэцэгийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон шийдвэр гарсан.

Баруун-Урт сумын 2 дугаар багийн иргэн Б.Сумьяа аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авч аймгийн Засаг даргад өгсөн.

Архивын тасаг: Лавлагаа 77, хуулбар 40 нийт 137 иргэдэд хөдөлмөрчдөд давхардсан тоогоор 1429 гаруй хадгаламжийн нэгжээр үйлчилсэн.

Цахимд 37 хадгаламжийн нэгж буюу 991 хуудас баримтыг скайнер, фотошопоор засварлаж, 9 хадгаламжийн нэгж буюу 421 хуудас баримтыг програмд шивж оруулаад байна.

Цагдаагийн газар: Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, уриалга, Монгол улсын Засгийн газрын тогтоол, Улсын болон аймгийн Онцгой комиссын шийдвэрийн хүрээнд аймгийн Засаг даргын 2020 оны А/54 дүгээр захирамжийг үндэслэн хот хоорондын зорчигч тээвэр, аймаг, сум хоорондын хөдөлгөөнийг түр хязгаарлан, Шинийн нэгний өглөө нар харах, уул, овоонд гарахыг хязгаарласан.

Цагдаа, дотоодын цэргийн командлагчийн тушаалаар Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүн өндөржүүлсэн бэлэн байдлын 2 дугаар зэрэгт шилжин ажиллаж аймгийн Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Авто тээврийн төвийн алба хаагч нартай хамтран Баруун-Урт сумын эргэн тойронд болон сумдын хэмжээнд 29 постуудад 68 алба хаагч нар үүрэг гүйцэтгэн ажиллав.

2020 оны эхний 2 сарын байдлаар тус аймгийн хэмжээнд 119 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэргийн гаралт 23 хэргээр буюу 24.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 39.1 хувийг илрүүлсэн нь улсын дундаж илрүүлэлтээс 19.4 хувиар дээгүүр үзүүлэлттэйгээр Улсын хэмжээнд тэргүүн байранд шалгарсан байна.

2020 оны 02 дугаарсарын 06-наас 07-ны шөнө тус аймгийн Халзан сумын төвд 11 удаагийн үйлдлээр бусдын орон байранд хууль бусаар нэвтэрч 47 мөнгөн аяга, 3 мөнгөн эмээл, гаанс, мөнгөн бөгж, монетон эзэмэг зэрэг иргэдэд 85 сая төгрөгийн хохирол учруулсан хэргийн Ү, Г нар бүлэглэн тээврийн хэрэгсэл ашиглан хулгайлсан хэргийг илрүүлэн холбогдох шалгалтыг хийж байна.

Сүхбаатар сумын нутагт үйлдэгдсэн 5 холбогдогчтой 6 удаагийн үйлдлээр бусдын 6 бод, 40 бог мал хулгайлж бусдад 12 сая төгрөгийн хохирол учруулсан хэрэг, Дарьганга сумын нутагт үйлдэгдсэн 2 холбогдогчтой 7 удаагийн үйлдлээр бусдын 9 тооны бод мал хулгайлсан хэргүүдийг тус сумдын хэсгийн төлөөлөгч нар мэргэжлийн өндөр ур чадвар гарган илрүүлэн холбогдох шалгалтыг хийж байна. Түүнчлэн мал хулгайлах гэмт хэрэг үйлдэхэд ашигласан “Портер”, “Бонго”, “Приус 20” маркийн автомашин, хоёр хятад мотоциклыг улсын орлого болгохоор битүүмжилжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: Тус газрын хорихоос өөр төрлийн ялын хяналтад 2020 оны 02 дугаар сарын байдлаар торгох ялаар шийтгүүлсэн урьд оны үлдэгдэл 11 ялтны 42470,0 төгрөгийн материал дээр шүүхийн шинээр 34 ялтны 29700,0 төгрөгийн шийтгэх тогтоол хүлээн авч, нийт 33 ялтанд 22700,0 төгрөгийн ялын биелэлтийг хангаж, 12 ялтны 49470,0 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийтэд тустай ажил хийлгэх 2019 оны үлдэгдэл 7 ялтны материал дээр шүүхээс шинээр 6 ялтны 1820 цагийн ялын материалыг хүлээн авч, 6 ялтны 2956 цагийг хорих ялаар солиулж, 1 ялтны 320 цагийг шүүхээс хүчингүй болгосон бөгөөд 1 ялтны 220 цагийн ялын хугацаа дуусаж, үлдэгдэл 5 ялтны ял эдлэлтэд хугацаа тавин ажиллаж байна.

Эрх хасах ялын урьд оны 24 ялтны 15758 хоногийн үлдэгдэл дээр 1 ялтны 730 хоногийн материал нэмэгдэж, 1 ялтны үлдэгдэл 72 хоногийн хугацаа дуусаж одоо 24 ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Хөрөн орлого хураах албадлагын арга хэмжээ авагдсан 2019 оны үлдэгдэл 2 этгээдийн 10000,0 төгрөг материал дээр шүүхээс шинээр 9 этгээдэд холбогдох 15166,4 төгрөг, нийт 25166,4 төгрөгөөс 7 этгээдийн 8999,8 төгрөгийн хөрөнгө орлогын хураасан авч орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр: Нийт 496 гүйцэтгэх баримт бичгээс : төлбөрийн биелүүлбэл зохих 244 гүйцэтгэх баримт бичгийн 1,879,749.9 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулснаас 58 гүйцэтгэх баримт бичгийн 241,960.2 мянган төгрөгийн төлбөрийг биелүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 23,7 хувь, мөнгөн дүнгийн бодит биелэлт 12,9 хувьтай байна.

Урьд оны мөн үетэй харьцуулахад гүйцэтгэх баримт бичгийн биелэлт 2,8 хувиар, мөнгөн дүн 5,5 хувиар өссөн, 13 гүйцэтгэх баримт бичгийг илүү хаасан байна.

Хүүхдийн тэтгэлгийн 247 гүйцэтгэх баримт бичгийн 298,157.4 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, хэсэгчлэн 49 гүйцэтгэх баримт бичгийн 32,906.2 мянган төгрөгийг, 4 гүйцэтгэх баримт бичгийн 8,680 мянган төгрөгийг дуусгавар болгон нийт 41,586.2 мянган төгрөгийг биелүүлсэн ажилласан.

Цагдан хорих байр: Харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн зохион байгуулж, цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан албан хаагчдын үүрэг гүйцэтгэлт, сахилга хариуцлага, сонор сэрэмжийг өндөржүүлэх үүднээс үүрэг даалгавруудыг тогтмол өгч хоригдол, хоригдогсдын хөдөлгөөнд байнгын хяналт тавьж гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж аюулгүй байдлыг ханган ажиллалаа.

Улсын бүртгэлийн хэлтэс: Тус хэлтэс 2020 оны 02 дугаар сарын байдлаар дараах бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлсэн байна.

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-239, анхны бүртгэл-42, өмчлөх эрх шилжих гэрээ-19, барьцааны гэрээ-128, бүртгэлд өөрчлөлт оруулах -2, лавлагаа хуулбар-29, нийт бичигдсэн гэрчилгээний тоо-62, нийт бичигдсэн лавлагааны тоо-29,

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-228% өмчлөх эрх шилжтх гэрээ-20, барьцааны гэрээ-115, бүртгэлд өөрчлөлт оруулах -9, лавлагаа хуулбар-8 нийт бичигдсэн гэрчлгээний тоо-81, нийт бичигдсэн лавлагааны тоо-7

Хуулийн этгээдийн бүртгэл

- 2020 оны 02 дугаар сарын байдлаар улсын бүртгэлд бүртгэлтэй нийт хуулийн этгээдийн тоо 1175. Үүнээс ХХК-4, Төрийн бус байгууллага-1, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн-3, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн-6, хуулийн этгээдийн нэр баталгаажуулалт хийсэн -7, хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналтын хуудас олгосон-9, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг-6,

Иргэний бүртгэл

- Иргэний бүртгэлийн тасаг нь 2020 оны 02 сарын байдлаар нийт 111 төрөлт, гэрлэлт 20, гэрлэлт цуцлалт 2, үрчлэлт 4, эцэг тогтоолт 8, овог нэр өөрчлөлт 7, нас баралт 28, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 33, үндэсний энгийн гадаад паспорт 83, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 46, иргэн, аж ахуй нэгжид олгосон лавлагаа 913 тус тус бүртгэгдэж олгосон байна

Дөрөв. Нийгмийн бодлогын хүрээнд

Боловсролын чиглэлээр: Японы Хүүхдийг ивээх сангаас Ховд, Завхан, Говьсүмбэр, Сүхбаатар аймагт хэрэгжүүлэх "Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох" төслийн баг аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан.

Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын судалгааг нэгтгэн гаргаж соёлын өвийн үндэсний төвд хүргүүлсэн.

Аймгийн ЗДТГ, НБХ-ээс гаргасан "Угийн бичгээ хөтлөж, удмын сангаа хамгаалъя" уралдааны удирдамжийг нийт соёл, урлагийн байгууллагуудад хүргүүлсэн.

Бага ангийн сурагчдад "Үндэсний хөтөлбөр"-ийн чадваруудыг эзэмшүүлэх байгалийн ухааны сургалтанд дэмжлэг болох, нэгж болон ээлжит хичээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх багш нарын ажлын байрандаа мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг дэмжих зорилгоор зохион байгуулсанан "Шилдэг нэгж хичээлийн" уралдааны дүнг гаргасан. Уралдааны хүрээнд нийт 20 нэгж хичээлийн хөтөлбөртэй танилцаж дүгнэлээ. Уралдаанд ирсэн багш нарын бүтээлээр төвийн 1.2.3.4-р сургуулийн бага ангийн багш нарт үзэсгэлэн гаргаж нийт 80 багш, сургалтын менежерүүд үзэж сонирхсон.

Ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчдийн судалгааг авч суурь боловсролын 883, бүрэн дунд боловсролын 564 гэрчилгээний захиалгыг БСШУСЯ-нд хүргүүллээ.

Сургуулийн өмнөх байгууллагуудын орчны судалгааг авч БСШУСЯ-нд хүргэсэн.

Сургалтын чанарыг сайжруулах зорилгоор "ХИМИЙН ХИЧЭЭЛД МАССААРАА МАНЛАЙЛЪЯ" аяныг 2019.10.15 - 2020.01.15-ны хооронд ЕБС-ийн 10,11-р ангийн сурагчдын дунд зохион байгуулж, аянд нийт 10-р ангийн 21 бүлгийн 538 сурагч, 11-р ангийн 25 бүлгийн 571 сурагч хамрагдсан. Аяны хүрээнд гарааны болон ахицын үнэлгээний шалгалт авсан бөгөөд сургуулиуд сурагчдын идэвхийг өрнүүлэн "Нээлттэй анги", "Мэтгэлцээн", "Бидний мэдэх хими", Түргэн бодолтын тэмцээн, Химийн хичээлийг хэн сайн мэдэх вэ? зэрэг төрөл танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулаж ажилласан.

Соёл урлагийн чиглэлээр:

Нийтийн номын сан: Хөл хорио тогтоосонтой холбогдуулан эцэг эхээр дамжуулан хүүхдэд гэрээр ном олгож үйлчилж байна.

Хөгжимт жүжгийн театр: Буриад улсын ардын жүжигчин, МУ-ын УГЗ удирдаач, хөгжмийн багш Нацагдорж урилгаар театрт 6 сарын хугацаанд хөгжимчдийн ур чадварыг нэмэгдүүлэх, хөгжмийн составыг нэмэгдүүлэхэд ажиллаж байна.

Ахмад зураач Ё.Бадарчаар үүдний хүлээлгийн танхим болон Фоёоныг засварлуулах ажлыг гүйцэтгүүлэн хүлээн авахад бэлэн болсон.

Эрүүл мэндийн чиглэлээр: Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан ажил эрчимжүүлэх тухай аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгаварыг гарган ААН, албан байгууллага, сумдын Засаг дарга нарт хүргүүлэн аймгийн Шуурхай штабыг ажиллуулж мэдээ, мэдээллийг тогтмол авч холбогдох газруудыг мэдээллээр хангах, урьдчилан сэргийлэх мэдээлээр иргэдийг ханган хүргүүлэн ажиллаж байна. Иргэдийг амны хаалтаар хангах, үнийг өсгөхгүй байх зорилгоор орон нутгийн төсвөөс 10 сая, аймгийн Нэгдсэн эмнэлэгт зайлшгүй шаардлагатай зөөврийн дижитал рентген худалдан авах 50 сая төгрөгийг Гамшгийг эрсдлийн сангаас шийдвэрлэлээ.

Аймгийн Засагдаргын захирамжаар "Болзошгүй гамшиг, Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн шуурхай мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг зохион байгуулах баг"-ийг томилон багийн гишүүдийг ЗӨСҮТ-тэй хамтран теле сургалтанд хамруулан багуудын төлөвлөгөө гарган ажиллаж халдварын үед дэлгэн ажиллуулах 70 орны тооцоог гарган 1-1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө шаардлагатай байгааг тооцон холбогдох байгууллагад уламжилсан. Мөн шинэ коронавирусын халдварын үед ажиллах хүний

нөөцийн судалгааг гаргаж, нэмэлтээр татан ажиллах боломжтой хүн хүчний судалгааг гарган шинэ коронавирусын талаар цахим мэдээллээр ханган сургалтад хамруулж байна.

Уламжлалт анагаах ухааны төвийн байранд АНЭ-ийн сэргээн засах эмчилгээ болон уламжлалт эмчилгээний тасгийг оруулж үйл ажиллагааг эхлүүллээ.

Эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгаруулах комиссын хурлыг зохион байгуулж 3 байгууллагын материалд дүн шинжилгээ хийж зөвлөмж өгч, ЭМДБ-ын болзлыг хангасан байгууллагуудыг урамшуулах аймгийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулаад байна.

Эрүүл мэндийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хурлыг зохион байгуулж Халзан сум, Уулбаян сумын ЭМТ, Мижарс хувийн эмнэлэг тус бүр 5 жил, Эрдэнэцагаан сумын Ачлал хувийн эмийн сан – 2 жилээр тус тус сунгасан.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн эмийн, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай жирэмснээс сэргийлэх эм, хэрэгслийн тендер зохион байгуулав.

Эрүүл мэндийн газрын даргын А/14 дүгээр тушаалаар “Тэмбүүг устгая” 2 дахь шатны үйл ажиллагаа зохион байгуулж аймгийн хэмжээний эрсдэлт бүлгийн иргэдийн судалгааг гарган шинжилгээ сорьц цуглуулах үйл ажиллагаа зохион байгуулж, нийт 2000 гаруй сорьц авч ХӨСҮТ-ийн хяналтын лабораторит хүргүүлээд байна.

Сар шинийн баярын өдрүүдэд нийт 192 эмч эмнэлгийн мэргэжилтэн 32 автомашин техниктэй эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж, нийт 14 эх, амьд төрсөн 14, яаралтай мэс асал 5, ЯТТ тасгаар 128, хэвтэн эмчлүүлэгсэд 121, түргэн тусламжийн дуудлагаар 128 иргэнд тус тус түргэн шуурхай үйлчилж арга хэмжээ авсан байна.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Засгийн газрын тогтоолын дагуу нийт тэтгэврийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж өндөр насны бүрэн тэтгэврийн доод хэмжээг 40000 төгрөгөөр, хувь тэнцсэн тэтгэврийн доод хэмжээг 30000 төгрөгөөр нэмэгдүүлж, 310001-500000 төгрөг хүртэлх тэтгэврийг 30000 төгрөгөөр, 500000 төгрөгөөс дээш тэтгэврийг 25000 төгрөгөөр нэмэгдүүлж нийт 8686 тэтгэвэр авагчийн тэтгэвэрт сард 297470,0 мянган төгрөг, жилд 3569640,0 мянган төгрөг олгохоор шийдвэрлэв.

Хөдөлмөр эрхлэлтийн талаар: 2020 оны 02-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 950 иргэнээс эмэгтэй 472, бүртгэлтэй ажилгүй иргэн 720 иргэнээс, эмэгтэй 355 иргэн байна. 65 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 57 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 54 иргэн буюу 94,7 % нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 39 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэв.

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй Заж ахуй нэгж байгууллагын 49 гадаад/хятад/ ажилтныг монгол улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоход байгуулгын зүгээс дэмжих саналыг олгож, хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан байна.

Нийгмийн халамжийн талаар: 2020 оны 02 дугаар сард олгох 1243 иргэний 227,150,250 мянган төгрөгийн тэтгэвэр, 1283 иргэний 138,888,240 мянган төгрөгийн тэтгэмж, 65 иргэний 9,836,500 мянган төгрөгийн ахмадын хөнгөлөлт, 246 иргэний 12,852,630 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, 582 иргэний 20,124,770 мянган төгрөгийн жирэмсэн эхийн тэтгэмж, 16 иргэний 2,300,000 төгрөгийн алдар цолтой ахмадын хөнгөлөлт, 2892 иргэний 142,609,740 мянган төгрөгийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн жагсаалт гарган арилжааны банкуудаар дамжуулан олгосон.

2020 оны 02-р сард 13 сумын 115 иргэний нийгмийн халамжийн тэтгэмж, 27 иргэний тэтгэвэр, 74 иргэний ахмадын хөнгөлөлт, 68 иргэний хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхийн 115 хувийн хэрэг, 161 иргэний жирэмсэн эхийн хувийн хэрэг, алдарт эхийн одонгийн 26, насны хишгийн 143 хувийн хэрэг хүлээн авч хянаад нийгмийн халамж үйлчилгээний мэдээллийн системд баталгаажуулсан. Сумдын мэргэжилтнүүдээс тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлт тусламж авах 197 иргэдийн жагсаалтыг баталгаажуулж, 93 иргэний тэтгэвэр тэтгэмжийн нөхөн олголтыг хийсэн ба тусгай хэрэгслийн захиалга гар таяг 8, даавуун бүс 6, ширэн бүс 11, тэргэнцэр 10, суултуур 10, өвдгөвч 20 ширхгийг гэрээт компанид захиалан иргэдэд хүлээлгэн өгсөн байна.

Аймгийн засаг даргын 2020 оны А/14-21 дүгээр захирамжаар хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан өрхөд 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүр сонгон шалгаруулах Асгат, Дарьганга, Баяндэлгэр,

Онгон, Уулбаян, Түмэнцогт, Түвшинширээ сумдын тендерийг Орон нутгийн өмчийн газраар зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 96 дугаар тогтоолоор Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.5-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны, хүүхдийн мөнгөн тэтгэмж авах хүсэлт гаргасан хүүхэд бүрд сар бүр бэлэн мөнгөөр олгох болсонтой холбоотой Сүхбаатар аймгийн хэмжээнд огт судалгаанд хамрагдаагүй өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхээр хүсэлт гаргасан 15 өрх өргөдөл гаргасан. Хүсэлт гаргасан өргөдлийн дагуу 15 өрхөөс өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг бүрэн авч, асуулгын хуудсыг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэв.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын амралт сувилалд 25 ахмад настан амарч сувилуулсан ба сувилалд амрагч нарт бариа засал, бумба, зөгийн балны татлага, хаш чулуун ор, шарлага, хүчилтөрөгчийн аппарат, физик эмчилгээний аппарат зэрэг эмчилгээ үйлчилгээг үзүүлж байна.

Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2, 3 дугаар заалтын дагуу 65 ба түүнээс дээш настай 2509 ахмадад 203410,0 мянган төгрөгийн насны хишгийг олгосон. Үүнийг насны ангиллаар задалж харуулбал:

65-69 насны 1108 хүнд 55400,0 мянган төгрөг

70-79 насны 943 хүнд 75410,0 мянган төгрөг

80-89 насны 419 хүнд 62850,0 мянган төгрөг

90 ба түүнээс дээш настай 39 хүнд 9750,0 мянган төгрөгийн насны хишгийг тус тус олгосон.

Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь заалтын дагуу албан байгууллагын харъяалалгүй ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх бэлтгэл ажлыг хангаж сумдын амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр, жагсаалтын хамт бүрдүүлсэн. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон Аймгийн засаг даргын захирамжийн дагуу албан байгууллагын харъяалалгүй ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан болно.

Тав. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд:

Барилга, хот байгуулалт, газрын харилцаа: Баруун-Урт сумын 1-р багт баригдсан "Цэлмэг" хотхоны 3-р ээлжийн 31 айлын орон сууцны барилгыг хүлээн авах улсын комисс аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдаж ажилласан ба комиссын гишүүдээс хугацаатай үүрэг өгч, хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна. Мөн Цагдаагийн алба хаагчдын 40 айлын орон сууцны барилгын эхний ээлжийн "А" блокын 20 айлын орон сууц, "Саруул" хотхонд баригдаж буй 25 айлын орон сууц, 6-р багт баригдаж буй "Даймонд" хорооллын орон сууцны барилга угсралтын ажилтай техникийн комисс танилцан холбогдох үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Газрын кадастрын мэдээллийн сангийн веб хувилбарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан нийт 24 өргөдөл бүртгэгдсэнийг ангилан үзвэл: эзэмшил газраа хэсэгчлэн шилжүүлэх 2 өргөдөл, Худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчилж авах 8 өргөдөл, шинээр газар эзэмших 2 өргөдөл, Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх 3 өргөдөл, Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалах 4 өргөдөл, эзэмшил газрын Талбай өөрчлөгдөх 3 өргөдөл, Төрөөс нөхөн олговортойгоор эргүүлэн авах (өмчлөх эрхийн газрын талбай хэмжээнд өөрчлөлт оруулах) 2 өргөдөл тус тус хүлээн авч бүртгэгдсэн байна.

Энэ сард аймгийн Засаг даргын 8 удаагийн захирамжаар 13 өргөдөл, Баруун-Урт сумын Засаг даргын 1 удаагийн захирамжаар 1 төрийн байгууллагын өргөдлийг тус тус шийдвэрлүүлж мэдээллийн санд бүртгэсэн. Газар эзэмших эрхийн гэрчилгээг 5 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулсан.

Газрын кадастрын мэдээллийн сангаас 24 иргэн аж ахуй нэгж, байгууллагад кадастрын үнэт цаасан дээр 62ш хувь баталгаажсан кадастрын зураглалаар үйлчилсэн.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны 40 дүгээр тушаалаар батлагдсан "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам"-ын дагуу Аймгийн хэмжээнд 2020 оны сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг цахим системд оруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Газрын цахим системд бүх сумдын газрын төлбөрийн ногдуулалтуудыг үүсгэж, татварын цахим системд илгээсэн. Газрын даамлууд цахим программаас нэхэмжлэх үүсгэх эрхтэй болсон бөгөөд төлбөр төлөлт онлайн болсон.

Сүхбаатар аймгийн бүх сумдын дэд бүтцийн судалгааг авч нэгтгэн боловсруулж /дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, холбоо харилцаа/ БХБЯ-нд хүргүүлсэн.

Аймгийн БТСГ-ын Хөл бөмбөгийн талбайн тамирчдын хувцас солих өрөө, ариун цэврийн өрөөний зургийн даалгавар, Дарьганга сумын зусланг орчин үеийн стандарт шаардлагыг хангасан амралт, хүүхдийн зуслан болгон өөрчлөх ажлын инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний зургийн даалгаврыг тус тус боловсруулан. Мөн Уулбаян болон Түвшинширээ сумдын ерөнхий боловсролын сургуулиудын их засвар шинэчлэлтийн ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг газар дээр нь үзэж танилцаж зургийн даалгаврыг боловсруулан холбогдох байгууллагуудаар баталгаажуулан захиалагч байгууллагуудад хүргүүлээд байна.

13 сумын хэмжээнд Барилгад хэрэглэх элс хайрга дайрганы үнэ болон байршлын судалгааг нэгтгэн авлаа.

Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг итгэмжлэлийн хүрээнд хамруулах ажлын хүрээнд лабораторийн чанарын гарын авлагыг боловсруулан аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэст албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна.

Мал аж ахуйн чиглэлээр: Сумдаас өвөлжилтийн талаарх мэдээллийг авч ХХААХҮЯ-нд мэдээлэхийн зэрэгцээ “Малчин” сэтгүүлд аймгийн өвөлжилттэй холбоотой цаг үеийн ажлын мэдээлэл өглөө.

2020 онд гаргах худгийн санал, бог малын угаалгын ванн, өвс тэжээлийн агуулах, саравч шинээр барих, засварлах ажлын судалгааг сумдаас авч Зах зээл ба бэлчээрийн удирдлага төслийн нэгжид хүргүүлээд байна.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нөөцийн судалгааг сум бүрээс авч нэгтгэн ХХААХҮЯ, аймгийн Онцгой комиссын шуурхай удирдлагын штабт мэдээлж байна. Түүнчлэн Баруун-Урт сумын хүнсний худалдааны томоохон 8 дэлгүүрийн нөөцийн судалгааг II/18, II/20-ны байдлаар гаргуулан аваад байна.

Мал эмнэлгийн чиглэлээр: Улсын онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны А/36, А/126 дугаар захирамж, 01 албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавин, шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж чиглэлийг иргэдэд хүргэн ажиллаж байна.

Эрдэнэцагаан сумын 1-р багийн малчин Ш.Э-ийн суурьт үхэр үхсэн гэсэн дуудлага мал эмнэлгийн тасагт ирсний дагуу аймгийн Мал эмнэлгийн газраас ажлын хэсэг ажилласан бөгөөд лабораторийн шинжилгээнд дээж материал авч шинжилгээнд хамруулсан, шинжилгээний дүнгээр халдварт өвчний үүсгэгч илрээгүй боловч хордлогын шинж тэмдэгтэй үхсэн нь тогтоогдсон.

Эрдэнэцагаан сумын Сүүн сэрүүн, Баруун-Урт сумын Тахилгатын арын хүрээ зэрэг газруудаас МЭЛабораторит үхэр-1, нохой-1 дээжүүд тус тус ирүүлсэн бөгөөд шинжилгээний хариугаар галзуу өвчин болох нь тогтоогдож хариуг сумдын Мал эмнэлгийн тасагт хүргүүлэн, сумдын Засаг даргын захирамжаар хэсэг газрыг хязгаарлалтын дэглэм тогтоож тухайн хот айлуудын мал сүрэгт баг хариуцсан малын эмчээр нь мал амьтны эрүүл мэндийн үзлэгийг хийлгэж галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: үхэр-40, хонь-1500, ямаа-1000 нийт 2540 толгой мал хамрагдаж халдваргүйтгэлийг стандарт аргагүйн дагуу хийж гүйцэтгэсэн.

Биокомбинат УӨҮГазраас “Шөвөг яр” өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг татан авч сумдын Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн захиалгын дагуу хуваарь гаргаад байна.

Уул уурхайн салбарт: Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулах 7 аж ахуй нэгжийн тээвэрлэлтийн чиглэлийг аймгийн Засаг даргын 2020 оны А/153 дугаар захирамжаар энэ оны 06 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаагаар түр тогтоож, зам засвар арчлалтыг ажлыг гүйцэтгэх, тээвэрлэлтийн стандартыг мөрдөж ажиллах үүрэг чиглэлийг өглөө.

Монгол Улсын Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан аймгийн нутаг дэвсгэрт Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа “Макс ойл”, “Монголиа

шин ий энерги”, “Вульф петролеум” ХХК-уудтай холбогдон үүссэн өрийг барагдуулах, эвлэрлийн гэрээ байгуулах боломжийг судлах аймгийн Засаг даргын А/27 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2 дугаар сарын 11-ний өдөр хуралдаж “Макс ойл” ХХК-аас ирүүлсэн хүсэлт, гэрээний төслийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулан өгсөн чиглэлийн дагуу эвлэрлийн гэрээ байгуулахаар ажиллаж байна.

Зам тээврийн салбарт: Баруун-Урт сумын 3-р багт баригдах 1,1 км хатуу хучилттай авто замын төсөвт өртгийг шинэчлэх, техникийн тодорхойлолт боловсруулах ажил гүйцэтгэж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Аймгийн Засаг Дарга, БОАЖС-ын 2020 онд бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, Хоггүй цэвэрхэн монгол аяны хүрээнд хог хаягдлын мэдээллийн самбарыг Баруун-Урт сумын 5-р багийн иргэн Б.Ганбаатартай 2.584.000 төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүллээ. Нийт 4 ш самбарыг гэрээнд тусгагдсан материал, тооцооны дагуу чанартай гүйцэтгүүлсэн. Дээрхи самбаруудыг Баруун-Урт сумын Дөрвөлж толгой, Халзан сумын 60-ын овоо, Асгат сумын Их уул, Сүхбаатар сумын Дархан хаан ууланд тус тус байршуулж ажиллалаа.

Монголчуудын уламжлалт баяр Цагаан сарыг тохиолдуулан БОАЖГ-аас нийт ард иргэд, орон нутгийг зорин ирж буй гадаад дотоодын жуудчдад зориулан “Цэвэрхэн шинэлцгээе” уриалгыг гарган иргэд рүү хандсан нөлөөллийн ажлуудыг хийлээ.

БОАЖГ-ын вэб сайт болон цахим хуудсаар дамжуулан 9 мэдээллийг 12326 иргэнд/давхардсан тоогоор/ хүргэж ажиллалаа.

Зургаа.Батлан хамгаалах салбарын хүрээнд:

Аймгийн Засаг даргын 2020 оны А/25 дугаар захирамжаар цэргийн бүртгэлийг 2020 оны 1 дүгээр сарын 20-28-ний өдрүүдэд Сүхбаатар аймгийн хэмжээнд зохион байгуулж мэдээ тайланг журмын дагуу нэгтгэж Батлан хамгаалах яам,Зэвсэгт хүчний Жанжин штабт тушаасан.

2019 онд Батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт сурталчилах, хэрэгжүүлэх ажлын талаар бусдыгаа хошуучлан ажилласан Түмэнцогт, Сүхбаатар, Түвшинширээ сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт мөнгөн урамшуулал олгохоор шийдвэрлэв.

Монгол Цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 99 жилийн ойг тохиолдуулан шагнуулах албан хаагчдын материалыг нэгтгэж Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлээд байна.

Өндөг насны тэтгэвэр тогтоолгох зорилгоор Зэвсэгт хүчин, Хилийн ба Дотоодын цэрэгт алба хаасан тухай архивын лавлагаа 5, хугацаат цэргийн албанаас түр чөлөө хүссэн 1 өргөдлийг холбогдох газруудад уламжлан шийдвэрлүүлсэн.

Долоо. Бусад салбарт хийгдсэн ажил

Стандарт хэмжил зүйн хэлтэс: Баталгаажуулалтын зөвлөлийн хурлыг 2 удаа хуралдуулж тохирлын гэрчилгээ хэрэглэх 15 аж ахуй нэгж байгуулагатай тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээг байгуулан ажилласан байна.

Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн тохирлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилт, Засгын газрын 291-р тогтоол, Стандартчилал хэмжилзүйн газрын тогтоол, журам, дүрэм, Аймгийн засаг даргын захирамж, Хэлтсийн даргын үүрэг даалгавар зэргийг хэрэгжүүлэх үүднээс эхний улирлын байдлаар 20 гаруй аж ахуй нэгжийн худалдаа үйлчилгээний газар тохирлын үнэлгээнд хамрагдсанаас: хүнсний дэлгүүр-5, минимаркет-11, Зоогийн газар- 1, пав караоке-1, тус тус тохирлын гэрчилгээ олголоо.

Хэмжилзүйн талаар: Тайлант хугацаанд иргэн аж ахуй нэгж байгууллагаас өдөр тутам ирэх хэмжих хэрэгсэл баталгаажуулах, шалгалт тохируулга хийлгэх санал хүсэлтийг хүлээн авч барагдуулан ажилласан. Энэ ажлын хүрээнд электрон болон механик жин- 13, цусны даралтын аппарат-1, цахилгаан тоолуур-2 , лабораторийн жин-0, тус тус баталгаажуулалт, шалгалт тохируулганд хамруулан ажилласан.

Салбар сангийн хүрээнд: Шинэ болон шинэчлэгдэн батлагдсан стандартаар 2 байгууллагад үйлчилж Мэргэжлийн хяналтын газарт 11 стандартын захиалгаар үйлчилсэн байна.

Найм. Сумдад зохион байгуулагдсан ажил

Баруун-Урт:

80-с дээш настай 219 ахмад настанд хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулсан. Мөн 90-с дээш настай 31 ахмад настанд аймгийн Засаг даргын бэлгийг багийн ажлын албадаар дамжуулан гардууллаа.

Төрийн дээд одон медалиар шагнуулахаар 27 иргэний материалыг сумын ИТХ-д уламжиллаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/160 дугаар захирамж, “Ажил эрчимжүүлэх тухай” сумын Засаг даргын А/29 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ажлын хэсэг байгуулагдаж тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагаар явж ажилласан.

Сумын шуурхай штабыг байгуулан 70513511 дугаартай утсан дээр мэдээллийг хүлээн авч, хариуцлагатай жижүүр томилон ажиллаж байна.

Аймгийн төвд ойр дэд бүтэц шугам сүлжээнд холбогдох боломжтой газарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аюултай хог хаягдлын цэг барих газрыг сонгон сумын Засаг даргын захирамжаар газар олгосон.

Хөдөө аж ахуй: Сумын сайн малчин шалгаруулах журмын дагуу 4-р багийн 2, 8-р багийн 13 нийт 15 малчин өрхийн ажлын үзүүлэлт, холбогдох материалыг журмын дагуу шалгаруулж 13 малчин өрхийг “Сумын сайн малчин”-наар тодрууллаа.

Сумын аюулгүйн нөөц өвснөөс 742 малчин өрхөд нийт 6575 боодол өвс буюу нэг малчин өрхөд 5-10 боодол өвсний тусламж дэмжлэг үзүүллээ.

Соёлын чиглэлээр: 2020 онд “Соёлын биет бус өвийн үзлэг” улсын хэмжээнд анх удаа зохион байгуулагдахтай холбогдуулан өв тээгчдийн шинэчилсэн бүртгэлийг маягтын дагуу гарган аймгийн угсаатны зүйн музейд 17 өв тээгчдийн судалгааг гарган хүргүүллээ.

Мөн соёлын өвийн төвөөс 2020 онд зохион байгуулагдах үл хөдлөх дурсгалт зүйлийн улсын үздэг зохион байгуулагдах ажлын хүрээнд сумын хэмжээний үл хөдлөх хөшөө дурсгалын судалгааг маягтын дагуу гарган аймгийн ИТХ-д хүргүүллээ. Сумын хэмжээнд нийт 53 үл хөдлөх хөшөө байна.

Гэр бүл хүүхэд хамгааллын чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Онц нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам”, БШУС сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтран баталсан “Гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй осол гэмтэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх” арга хэмжээний удирдамжид заасны дагуу хүүхэд, гэр бүлийн эрсдэлийг тодорхойлж, зураглал гаргах түргэчилсэн үнэлгээний судалгааг хийж, сумын зорилтот бүлгийн болон эрсдэлт бүлгийн 73 өрхийн 215 хүүхэд, жирэмсэн 284 эхийг судалгаанд хамруулж, нэгдсэн дүн мэдээг аймгийн ГБХЗХГ-т хүргүүллээ.

Эрүүл мэндийн чиглэлээр: 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр хүртэл нийт 2896 хүнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:

- Өвчний учир амбулаторит 32,7 %
- Урьдчилан сэргийлэх үзлэгт 8,6 %
- Идэвхтэй хяналтанд 44,7 %
- Дуудлагаар гэрийн үзлэг 3,03 %
- Гэрийн идэвхитэй үзлэгт 10,7 %-ийг тус тус эзэлж байна.

Эрсдэлт бүлгийн 0-5 хүртэлх насны хүүхдүүд, жирэмсэн эмэгтэйчүүд, 65-аас дээш настай, цусны даралт ихсэх, сахарын өвчтэй хүн амын гэрийн эргэлтийг сайжруулах, гэрийн эргэлтийн давтамжийг нэмэгдүүлж, сулруулахгүй байх, хөнгөн болон дунд хэлбэрээр өвчилсөн тохиолдлыг гэрээр эмчлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

“ТОМУУГ ТОЙРЧ ЧАДАХГҮЙ Ч ,СЭРГИЙЛЖ ЧАДНА” уриалгыг гарган, амны хаалт, гарын ариун цэвэр сахиж, санитол тогтмол хэрэглэх зөвлөмжийг ард иргэд, албан байгууллага, олон нийтийн худалдааны газруудын дунд хэрэгжүүлж тогтмолжуулах арга хэмжээг авч ажилласан.

ТТӨ, шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны материал болон зөвлөмжүүдийг Халдварт өвчин судлалын үндэсний төв, Эүүл мэндийн яам, ЭМЯ-ны олон нийттэй харилцах тандалт шуурхай удирдлагын

хэлтэс, World Health Organization Mongolia, Эрүүл мэндийн газар Сүхбаатар фэйсбүүк, вэб цахим хуудсаар авах, олон нийтэд түгээж гэрээр нийт 3 төрлийн гарын авлагыг 145 өрхийн 499 хүнд тарааж мэдээлэл хүргэсэн байна.

Корона вирусээс урьдчилан сэргийлэх ДЭМБ-ын 10 зөвлөмжийг ӨЭМТ-үүдээр үйлчлүүлсэн 213 хүнд сургалтаар хүргэж, корона вирусээс урьдчилан сэргийлэх санамж бүхий хавтас ажиллуулж 69 айл өрхөд, ЦУОШГ-ын 15 албан хаагчид COVID 19 вирусээс сэргийлье сургалтыг явууллаа.

Баяндэлгэр:

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Сумын засаг даргын 2020 оны А/11 дүгээр захирамжаар шинэ корона вирусын халдвар дэгдэхээс урьдчилан сэргийлэх үүднээс сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, согтууруулах ундаа худалдан борлуулдаг үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарийг 09-22 цаг болгон, интернэт РС тоглоомын газар билльард зэрэг газруудын үйл ажиллагааг бүрэн зогсоож цагдаагийн байгууллага хяналт тавин ажиллаж байна.

Сумын хэмжээнд олон нийтийг хамарсан соёл урлаг, хурал, лекц дугуйлан зэрэг арга хэмжээг байгуулах ажлыг тодорхойгүй хугацаагаар хориглоод байна.

Сумын засаг даргын тамгын газрын даргын 2020 оны А/03 дугаар тушаалаар шинэ төрлийн корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан хүүхдийг хараа хяналттай байлгах, аюулгүй байдлыг хангах зорилгоор 02 дугаар сарын 17-ны өдрөөс 02 дугаар сарын 28-ны өдрийг дуустал ажлын цагийг 09-12, 13 -16 цаг болгон богиносгож өөрчиллөө.

Нийгмийн халамж: Эрүүл мэндийн төвтэй хамтарч зорилтот өрх болон хүнсний эрхийн бичигт хамрагддаг 12 өрхөд 92000 төгрөгний маск болон ватамин олголоо.

Эрүүл мэндийн төв: Цагдаагийн тасагтай хамтран 10 аж ахуй нэгжээр явж үйлчлүүлэгч болон ажилчдад амны хаалтаа байнга зүүж байх талаар үйлчлэгч болон үйлчлүүлж буй хүмүүст гараа угаах аргыг зааж урьдчилан сэргийлэх зөвлөмжүүдийг хүргэв.

Амны хаалтны хангалт хэрэгцээ шаардлага их байгаа тул ажилчид амны хаалт хийж эрсдэлт бүлгийн иргэдэд олгоод байна.

Байгаль орчин: Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгууллаа.

Мерсу Сор олон улсын байгууллагатай хамтран бэлчээрийн менежментийг сайжруулах төслийн хүрээнд КШК худгийг засварлан сэргээх чиглэлд сонгогдсон худгийн байршлыг тогтоож солбицлыг төслийн нэгжид хүргүүлэв.

Сумын засаг даргын 2020 оны А/07 дугаар захирамжаар “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах” ажлын хэсгийг байгуулж, журмын дагуу агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг хийлээ.

Хөдөө аж ахуй: Аймгийн Засаг даргын А/36 дугаар захирамж, 01 дүгээр албан даалгавар, сумын Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд худалдаа үйлчилгээний газруудад төлөвлөгөөт шалгалт хийж хэрэглэх болон хадгалах хугацаа дууссан, чанарын аюулгүй байдал хангахгүй 10 төрлийн 47 ширхэг 127600 төгрөгний хүнсний зүйлийг хураан авч устгав.

4 багийн 329 өрхийн 6580 адуунд им тамганы бүртгэл хөтөлж, цахим мэдээллийн санд оруулан адууны им тамганы судалгааг гаргаж ХХААГазарт явуулсан.

Дарьганга:

Нэг. Төрийн удирдлагын чиглэлээр:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлыг 2 удаа хуралдаж дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

1/. Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын үзлэгт холбогдуулан сумын үл хөдлөх дурсгалын жагсаалт

2/. УИХ-ын ээлжит сонгууль болохтой холбогдуулан 4 хэсгийн төв болон зурагт хуудас сурталчилгааны материал байршуулах байршил

3/. Төрийн дээд шагналын тодорхойлолт

4/. Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг томилох тухай

5/. ИТХ-ын ажлын албаны 2020 онд хийх ажлын төлөвлөгөө

Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан сумын Засаг даргын захирамжаар 24 цагийн хариуцлагатай жижүүрийг 34 төрийн албан хаагчийг оролцуулан томилж 02.15 -03.02 ныг хүртэл ажиллуулж байна.

Сумын Онцгой комисс 3 удаа хуралдаж цаг үеийн асуудлаар мэдээлэл солилцон, гамшгаас хамгаалах штабын бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлэн, 02.23 -02.26 ныг хүртэлх хугацаанд “ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛ”-ийг сумын төвийн 3 цэгт ажиллуулж 30 төрийн албан эргүүлийн үүргийг гүйцэтгэлээ.

Хууль эрх зүйн чиглэлээр: Сумын Засаг даргын 2020 оны А/13 дугаар захирамжаар “Үйлчилгээний газруудад хяналт шалгалт, хууль эрх зүйн сурталчилгаа зохион байгуулах” ажлын хэсгийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан 2 өдөр аж ахуйн нэгж, үйлчилгээний газруудад ажиллуулж, согтууруулах ундаа, тамхины худалдаанд хяналт шалгалт хийж, Хөдөлмөр эрхлэлт, Татвар, Авлига, Эрүүл мэнд, Байгаль орчны чиглэлээр сурталчилгаа хийж, 37 цэгт 1-3 төрлийн гарын авлага тараах материалыг тарааж ажиллав.

Эрүүл мэндийн чиглэлээр: Корона вирусээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумын Онцгой комисс, Гамшгаас хамгаалах штабын гишүүд, төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон баг, хариуцлагатай жижүүрүүд нь сурталчилгааны ШТОРК бусад УХУУЛГЫГ ЦАХИМ орчинд болон ТОДОРХОЙ ЦЭГҮҮДЭД БАЙРШУУЛАХ ажлыг өдөр бүр зохион байгуулж ажиллаж байна. Тухайлбал: ЕБС, Цэцэрлэгийн багш нар 326 сурагчид цагаан сараар айл хэсэхгүй байх мэдээг хүргэж, 200 айлын хашааны хаалганд ГАРЫН АВЛАГА, УРИАЛГА наав. Сумын ИТХ-ын төлөөлөгчид УРИАЛГА гаргаж цахимын 2 сүлжээнд байршуулахад 6 шэйр, 24 лайк хийгдсэн байна.

ЗДТГазраас УРИАЛГА, ШЭЙР –ийг 3 цахимд байршуулж 60 гаруй лайк, шэйр хийгдсэн. ЭМТ-өөс 3 цахим орчинд болон аж ахуйн нэгж, байгууллагуудад УРИАЛГА, ШТОРК -ийг байршуулж 200 гаруй иргэд мэдээлэл авсан байна. Соёлын төвөөс УРИАЛГА, ШТОРК-ийг шэйрлэж 2 цахимд байршуулж 30 гаруй иргэд мэдээлэл авсан.

Төрийн байгууллагуудад 0-5 насны хүүхэдтэй 56 эх ажиллаж байгаа бөгөөд эдгээр эхчүүд болон ажилчдад 2 цагаар хорогдуулсан цагаар ажиллуулах шийдвэрийг гарган, хэрэгжүүлж байна.

Сумын хэмжээнд ажиллаж байгаа эмийн эргэлтийн 2 санд Эмийн эргэлтийн сангийн зөвлөл хяналт хийж амны хаалт, ариутгалын бодис, хэрэгслийн судалгааг авсан.

Байгаль орчны чиглэлээр: Сумын Засаг даргын захирамжаар 15 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилон агаар бохирдуулагчийн тооллого зохион байгуулж 390 өрхөд судалгааг 20 асуулгаар хийж, тайлан мэдээг гаргалаа.

Хөдөө аж ахуй, мал эмнэлгийн үйлчилгээний чиглэлээр: Сумын МЭҮТ-т халдваргүйтгэл ариутгалын хлорын шохой 50 кг, Aniguavd 10 кг, HI-cop 1 тн усанд найруулах хэмжээгээр нөөцлөгдсөн бөгөөд эдгээр бодисоор гахай үржүүлгийн 2 цэг, тахианы 1 цэг, түүхий эдийн 2 цэг, нэгдсэн хогийн цэгт дэхь устгасан 60 нохой зэрэгт ариутгалыг хийлээ.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Сумын хэмжээний ядуурлаас гаргах 27 зорилтот өрхийг зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталлаа.

ХХҮГ-аас зээл авч үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн бүтээгдэхүүнийг борлуулах БОРЛУУЛАЛТЫН цэгийг байгууллаа.

Наран:

Засаг дарга болон Тамгын газрын холбогдох албан тушаалтнуудад иргэдээс 74 өргөдөл гомдол ирүүлсэнийг хугацаанд нь шийдвэрлэсэн. Хугацаа болоогүй 1 өргөдөл, шийдвэрлэлт 98.6 хувьтай байна.

Сумын засаг дарга цаг үеийн асуудлаар багийн засаг дарга нар болон ЗДТГ-ын мэргэжилтэн, ЕБС-ийн багш, эмч нарын бүрэлдэхүүнтэй 2 багийн 370 гаруй айл өрхөөр явж иргэдийн санал бодлыг сонсож ажил хэрэг болгон ажиллалаа.

Малчин телевизтэй хамтран 2019 онд хэрэгжүүлсэн “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, шинэлэг бүтээлч ажил”-ын талаар нэвтрүүлэг хийж иргэдэд ажлаа тайлагнаж ажиллалаа.

Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийсний зэрэгцээ Онцгой комиссыг 2 удаа хуралдуулж асуудлыг тухай бүр нь шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.

Коронавирусээр урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд анхааруулга санамжийг иргэдэд хүргэхийн зэрэгцээ хөдөлгөөнт эргүүлийг томилон ажиллуулж байна. Төрийн албан хаагчид санаачлан 358ш амны хаалтыг оёж сумын нөөцөд хувь нэмрээ оруулсан байна.

Аймгийн сайн малчнаар 3 иргэн, сумын сайн малчнаар 8 иргэн шалгарсан ба уг үйл ажиллагаанд зориулж сумын засаг даргын нөөц сангаас 2.0 сая төгрөг зарцуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр “Сумын төвийн гэрэлтүүлэг”-ийн ажил хийгдэж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, соёл урлагийн чиглэлээр:

ХАБЭАхуйн зөвлөлөөс “ Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” аяныг 02 сарын 01-ний өдрөөс 05 сарын 25-ныг хүртэлх хугацаанд зарлаж удирдамжийг гаргаж 12 төрийн болон төрийн бус, ААНэгжүүдэд хүргүүллээ.

Сумын эрүүл мэндийн төвтэй хамтран зорилтот бүлгийн 9 өрхөөр явж өрхийн нөхцөл байдалтай танилцан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөгөө өгч 18 хүүхдэд витамин, амин дэм олгосон.

ЗДТГ-ын албан хаагчид энэ сард 78 хүнд 21 чиглэлээр мэдээлэл өгч ажилласан байна.

“Бүрдүүл нягтал” аяны удирдамжийн дагуу тэтгэвэр, тэтгэмжийн нийт 321 хувийн хэргийн бүрдлийг нягтлан WAIS программтай тулгалт хийж 12 хувийн хэргийн зөрчлийг арилган ажилласан.

Улсын бүртгэл: Иргэний бүртгэлийн үйлчилгээг иргэний хүсэлтийн дагуу тасралтгүй хүргэж ажиллаж байна. Нийт 41 иргэний бүртгэлийг холбогдох бичиг баримтыг хүлээн авч хүсэлтийн дагуу шийдвэрлэж ажиллалаа.

Хөдөө аж ахуй: Хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 6 аж ахуй нэгжид хяналт шалгалт хийж хаяг шошгын зөрчилтэй, хугацаа дууссан, муудсан, сав баглаа боодол гэмтсэн 18 нэр төрлийн 173267 төгрөгний бараа бүтээгдэхүүнийг хураан авч устгал хийж ажилласан.

Гахай шувууны өрхийн аж ахуй эрхлэгч 1 өрхөд зөвлөн туслах арга хэмжээ авч ажилласан.

Сумын аюулгүй нөөцийн 310 боодол өвсийг малтай өрхүүдэд худалдсан.

Боловсрол: Боловсролын хүрээлэнгийн захирлын “Телевизээр явуулах хичээлийн агуулга, хуваарь батлах тухай” тушаалын 1-р хавсралтыг эцэг эхчүүдэд танилцуулж гарын үсэг зуруулж “Теле” хичээлийг тасралтгүй үзүүлж, хичээл сургалтаас хоцроохгүй байх зөвлөмжийг багш нар суралцагчдад хүргэж ажилласан.

Дарьганга суманд зохион байгуулагдсан Ахмад багш Н.Цэвэлмаа агсны нэрэмжит "Уянгын тойрог" богино өгүүллэгийн тэмцээнд ахлах насны ангилалд нийт 35 сурагч амжилттай оролцлоо.

Алсагдсан хөдөөгийн 40 өрхийн 20 сурагчид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан.

Эрүүл мэнд: “Тэмбүүг устгая” аяны хүрээнд зорилтот бүлгийн 104 өрхийн зураглал хийж, 168 иргэнээс сорьц авах судалгаа гаргаж 100% хамруулж Аймгийн нэгдсэн эмнэлгийн лабораторт стандартын дагуу хүргүүлсэн.

Тусгаарлах өрөөг бэлдэж, хувийн хамгаалах өмсгөл болон халдваргүйтгэлийн бодист үнэлгээ хийж, нөхөн хангалт хийсэн.

Иргэдэд корона вирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг өгч сумын төвийн болон хөдөөний 108 айл өрх, сургуулийн 49 сурагчид гар угаах болон маск зүүх сургалтыг хийлээ.

Өөр аймаг сумаас ирсэн /Замын-үүд, Хил боомт, БНХАУ/ 12 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг хийж хяналтанд авч ажиллаж байна.

Сүхбаатар:

Сумын Засаг даргын А/28 дугаар захирамжаар гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг томилгоожуулан хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг ханган Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгон Сумын онцгой комиссын штабын байрыг бэлтгэж 24 цагаар жижүүрийн үүрэг гүйцэтгэж байна. Сумын штабын утас 88510138

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг байнгын бэлэн байдалд шилжүүлэх талаар газар дээр нь очиж үүрэг даалгавар өгч, сумын нөөц бололцоонд тулгуурлан ЕБСургуулийн 58 ортой дотуур байрыг шинэ корона вирусийн халдвар бүртгэгдсэн

тохиолдолд сэжигтэнийг тусгаарлах зориулалтаар бэлтгэсэн. Мөн маск, хувцас хэрэгслийн бэлэн байдлыг хангах үүднээс сумын Засаг даргын шийдвэрээр 3 сая төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэн Эрүүл мэндийн төвд үүрэг болгосон.

Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг сумын төвд ажиллаж байгаа чанга яригч, Радио үзэлээр өдөрт 2 цаг тутамд тогтмол явуулж, Сумын вэб сайт, ЗДТГазар, Цэцэрлэг, ЭМТөв зэрэг газруудад урсдаг электрон самбараар 24 цагийн туршид, Багийн засаг дарга нар 17, 18 –ны өдрүүдэд сумын төвийн 450 өрхөд зөвлөмж хүргэж ажиллаж байна. Хөдөөгийн малчдад масс мессэж үйлчилгээг ашиглан 500 өрхөд сэрэмжлүүлэг хүргэж ажиллалаа.

Сумын хэмжээнд 2-р сарын 23-ны өдрөөс сумаас гарах, орох бүх чиглэлийн хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд: Төрийн байгууллагын ажилтан албан хаагчдыг хамруулсан нийт 3 чиглэлийн хөдөлгөөнт постыг 24 цагаар томилгоожуулан хуваарьт шилжүүлэн ажиллуулж байна.

Соёл урлагийн чиглэлээр: Д.Сүхбаатарын мэндэлсний 127 жилийн ойг угтан Д.Сүхбаатарыг хэн сайн мэдэх вэ зохион бичлэгийн уралдааныг зарлаж шалгаруулсан.

Монголчуудын эрт дээр үеэс тоглож наадаж ирсэн оюуны болоод соёлын үнэт өв болох үндэсний тоглоом наадгайн нэгэн төрөл болох "Алаг мэлхий өрөх", "Бөгж нийлүүлэх" зэрэг тоглоомын аргачлалыг тайлбарлаж өглөө.

Аймгийн БСУГ-аас зохион байгуулсан "Хулгана жил-2020" аяны хүрээнд сумын хулгана жилтэний судалгааг гаргаж өндөр настан болон залуу үеийн төлөөлөл 4 иргэний мэндчилгээг сумын иргэдэд цахимаар хүргэсэн.

Түвшинширээ:

Төрийн удирдлагын чиглэлээр: Сумын Онцгой комисс нийт 4 удаа хуралдаж, цаг үеийн байдал болон сумын хэмжээнд хөл хорио тогтоох, сумын шуурхай штаб, хариуцлагатай жижүүр, хөдөлгөөнт эргүүл пост гаргах ажлын хуваарь зэрэг асуудлаар хэлэлцэж холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Сумын шуурхай штабыг байгуулан 24 цагаар жижүүрлэн ажиллаж байна.

Төсөвт байгууллагууд цагдаагийн тасагтай хамтран сар шинийн баяр болон шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлгөөнт эргүүлийг 02 сарын 15-аас эхлэн 3 сарын 2-ыг хүртэл хуваарь гарган ажиллаж байна. Уг ажлын хүрээнд 02 сарын 18-ыг хүртлэх байдлаар гадны дугаартай 12 тээврийн хэрэгсэл, өөрийн аймгийн дугаартай 56 тээврийн хэрэгсэлийг шалгаж, зорчигчдод санамж сэрэмжлүүлэг өгсөн байна.

ЭМТөв 2020 оны 1 дүгээр сарын 15-аас эхлэн нийт 13 ажилтан бүрд өдөрт 2 ширхэг амны хаалтаар хангаж, аарц чацарганаар дархлааг дэмжин ажиллаж байна.

ЗДТГ-аас амны хаалтгүй иргэдэд үйлчлэхгүй болохыг мэдэгдсэн зарлалыг байгууллагын гадна болон өрөө тасалгаануудын үүдэнд нааж, зөвхөн амны хаалттай иргэдэд үйлчилж байна. Мөн иргэдэд уламжлал сар шинийн баярыг тэмдэглэхгүй байх талаар уриалгыг сумын ИТХ, гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх зөвлөлөөс сумын цахим хуудсанд байршуулан уриаллаа.

ЕБС, Соёлын төв нь 0-5 насны хүүхэдтэй эцэг эхчүүддээ чөлөө олгож, зарим ажилчдаа өдрийн 6 цагаар ажиллуулж байна.

"Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлцгээе" гарын авлага брошурыг сумын ИТХ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс гарган иргэдэд тарааж байна. Мөн албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гадна хаалга бүрд ДЭМБ-аас зөвлөсөн 10 зөвлөмжийг хэвлэн байршуулаад байна.

Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол болон сумын Засаг даргын 2019 оны 2 дугаар сарын 13-ны А/07 "Хурдан морины уралдаанд хориг тавих тухай" захирамжийг нийт ард иргэд, уяачдын холбоонд цахим хэлбэрээр сурталчлан таниулах ажил хийгээд байна.

Хүн ам, өрхийн мэдээллийн санд дараах баяжилтыг хийлээ. Шилжин ирсэн болон явсан 7 өрхийн 16 иргэний шилжилт хөдөлгөөн, шинээр мэндэлсэн 2 хүүхдийг нэмж бүртгэсэн.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

2020 онд хийгдэх ЕБС-ийн хичээлийн I байрны их засварын ажлын зургийн даалгаврыг хийлгээд байна.

2019 оны жилийн эцсийн А картыг баг тус бүрээр архивлаж, үдэж цэгцлэв. Арьс ширний падааныг баталгаажуулж, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлэв. Монгол

улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан мал зүйчдын улсын зөвлөлгөөнөөс гарсан ХХААХҮ-ийн сайдын албан даалгаврын дагуу ажил эрчимжүүлэх ханган ажиллах тайланг гаргаад явуулахад бэлэн болгоод байна. Улс, бүс, их хурд, аймаг, сумын наадамд уралдсан морьдын судалгаа сүүлийн гурван жилээр гаргаж, аймгийн ХХАА-н газарт хүргүүлэв.

**Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл,
Эрүүл мэндийн чиглэлээр:**

Нийгмийн даатгалын санд 2 дугаар сарын хувьд ЭМД-д 22хүний 1779000 төгрөг, СДД-д 36 хүний 2137100 төгрөг, НДШ-д 24 ААНэгж төсвийн байгууллагын 32306729 орлого одоогоор ороогүй байна.02 сарын тэтгэвэрт 2 банкаар 397 хүнд 142385571 сая төгрөгний тэтгэвэр олгосон. шинээр 19 хүн тэтгэвэрт гарсан байна. 112000000 сарын тэтгэвэрийн санхүүжилт авсан.

Хичээл сургалтын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан хүүхдийг хараа хяналттай байлгах, аюулгүй байдлыг хангах, гэрийн нөхцөлд шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх арга замыг сургуулийнхаа Түвшинширээ ЕБС цахим хуудас болон сумын цахим хуудсаар дамжуулан эцэг эх асран хамгаалагчдад чиглэл зөвлөмж өгч ажиллаж байна.

ЕБС болон цэцэрлэгийн багш нар гэрээр ажиллаж, ангийн хүүхдүүдтэй цахимаар холбогдож теле хичээл үзэх, нэмэлт даалгавар өгөх, гэрээр явж сурагчдынхаа теле хичээлийн тэмдэглэлийн үйл ажиллагаатай танилцаж байна.

Багш ажилтнуудыг богиносгосон цагаар чиглэл өгч ажиллуулж байгаа ба 2 багш 1 ажилтан 1 хариуцлагатай жижүүрийг байнга хуваарийн дагуу ажиллуулж байна. Ингэснээр 0 – 5 насны хүүхэдтэй болон сургуулийн бага насны хүүхэд харах хүнгүй багш ажилтнуудыг гэрээр нь ажиллуулж байна. Байгууллагууд жижүүрт гарч буй болон ажлын байран дээр ажиллаж буй албан хаагчдад шинэ коронавирусээс хамгаалах, дархлааг дэмжих, халдваргүйжүүлэх арга хэмжээг авч маскыг тогтмол зүүлгэж цагаа, чацарганаар үйлчилж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: ЭМТөв бүх ажилчиддаа 1 удаагийн маскийг өдөрт 4 удаа тавьж өгч, дархлаа дэмжих аарц, чацарганаар өдөр бүр хангаж байна.

COVID-19 вирусын эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор комбинзон маск, гутал зэрэг хамгаалах хэрэгсэлүүдийг өөрийн нөөц бололцоогоор авч эхлээд байна.

Түмэнцогт:

Төрийн удирдлагын чиглэлээр: Засаг даргын “Хурдан морины уралдаанд хориг тавих тухай” захирамжаар 5 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд тус сумын нутаг дэвсгэрт хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглож хяналт тавин ажиллаж байна.

Сумын онцгой комиссын 01 тоот хуралдааны шийдвэр, Засаг даргын А\20 дугаар захирамжаар Шинэ төрлийн “2019-nCov” вирусын тархалтаас урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах зорилгоор ЭМТөвд нэн шаардлагатай байгаа эм, тоног төхөөрөмж худалдан авахад зориулж Засаг даргын удирдлагыг хэрэгжүүлэх зардлаас 1580.700 төгрөгийг зарцуулсан.

Байгаль орчны чиглэлээр: Засаг даргын А\16 дугаар захирамжаар золбин нохойг устгах ажлыг зохион байгуулж 89 нохой устгаж анчингийн ажлын хөлс, нохой устгалын үйл ажиллагааны урсгал зардалд Засаг даргын удирдлагыг хэрэгжүүлэх зардлаас 1.143.500₮ зарцуулсан.

ХААТасагтай хамтран 15 ААНэгж байгууллагад орчны цэвэрлэгээ хийх талаар 2 удаагийн албан мэдэгдэл хүргүүлж орчны цэвэрлэгээ сумын төвийн хэмжээнд зохион байгуулж 7,5 тн хог хаягдал нэгдсэн хогийн цэг дээр төвлөрүүлсэн.

Мөн “Ус-Дулаан” ОНӨҮГазар нэгдсэн хогийн цэгийг түрж цэгцлэх ажлыг зохион байгуулж 180м³ тайлбайн хогийг түрж, гадна талаас 8,4 тн хог хаягдал, сэг зэмийг ачиж тээвэрлэжнэгдсэн хогийн цэгт төвлөрүүлсэн.

Мал эмнэлгийн тасаг: Малчид болон мал бүхий иргэдэд зүй бусаар хорогдсон малын сэг зэм, халдварт өвчин, ариутгал халдваргүйжүүлэлт хийх талаар мэдээ мэдээлэл өгч ажиллалаа. Аж ахуйн нэгж дэлгүүр хувь хүний гар дээрээс гахай тахиа шувууны мах өндөг зэргийг худалдаалахгүй байх заавар зөвлөмж, мэдэгдэл хүргүүлээ.

Аймгийн мал эмнэлгийн газарт 70518382 дугаарт өдөр болгон мэдээ мэдээлэл хүргэн ажиллаж байна. Сар шинийг угтан хөдөө аж ахуй тасаг ЗДТГазартай хамтран дэлгүүр хоршоонд зөвлөн туслах хяналт шалгалт хийх ажилд хамтран ажиллаа.

ХААТасаг: Сумын засаг даргаар батлуулсан удирдамжийн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч ААНэгж дэлгүүрүүдэд хяналт шалгалтыг хийж коронавирусын талаар мэдээлэл өгч ажиллалаа. Хяналт шалгалтад 15 ААНэгж дэлгүүр хамрагдснаас 5 дэлгүүрээс хадгалах хугацаа дууссан, хадгалалтын горим алдагдсан, хаяг шошгоны зөрчилтэй 13 нэр төрлийн 212200 мян.төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч устгал хийсэн.

Мөн коронавирустай холбоотой гарсан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор дээрээс гарсан шийдвэрийн дагуу суманд үйл ажиллагаа явуулж байгаа 2 караоке, 15 ААНэгж дэлгүүрүүдэд 4 удаа албан мэдэгдэл, албан тоотыг хүргүүлж ариутгал халдваргүйжүүлэлт, амны хаалттай иргэдэд үйлчилж байгаа эсэх, орчны цэвэрлэгээг тогтмол хийж байгаад хяналт тавин ажиллаж байна.

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр: ХХҮГ-ын даргын 2020 оны 2 сарын 05-ны өдрийн удирдамж болох “Бүрдүүл нягтал” аяныхүрээнд 588 хувийн хэрэг хянан шалгаж илэрсэн зөрчлүүдийг арилгасан.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй 409,0 хүртэлх оноотой өрхүүдээс квотын дагуу 27 өрхийг сонгож Иргэдийн төлөөлөлөгчдийн хурлын тэргүүлэгчдээр батлуулж шийдвэр, мэдээллийг хүргүүлсэн.

Малжуулах хөтөлбөрт хамрагдсан 1 иргэн 1 болон 2 сарын 400000 төгрөг тушааж баримтыг хүлээн авсан.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг иргэдэд сурталчилах ажлыг зохион байгуулж, хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор багуудын засаг дарга нартай эрүүл мэндийн даатгал, сайн дурын даатгалын гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас баталсан малчин, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэний нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох хуулийн чиглэлийн талаарх мэдээллийг нийт 85 иргэнд хүргэсэн. Зөвшөөрлийн хуудасаар тэтгэвэр олгох журмын дагуу итгэмжлэлээр тэтгэвэр авагч 5 иргэнд зөвшөөрлийн хуудасаар тэтгэврийг олгож байна. Банк солих хүсэлт гаргасан 1 тэтгэвэр авагчын өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэн.

Эрүүл мэндийн төв: Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилчдад өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн талаар танилцуулан 24 цагийн хариуцлагатай жижүүрийн хуваарь томилогдон өдөр бүр эрүүл мэндийн газар болон засаг даргын тамгын газарт мэдээгээ өгч байна.

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны 50 ортой эмнэлэг дэлгэхээр шийдвэрлэсэн.

Эрсдэлт бүлгийн хүүхдүүдийн судалгааг багийн дарга нараар гаргуулан 62 хүүхдэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж амны хаалт, 2 төрлийн витаминаар витаминжууллаа.

Айл өрхүүдээр явж гар угаах дараалал зааж гар угаах зөвлөмж тарааж ариутгалын бодис бэлтгэж гэрээ ариутгахыг зааж зурагт хуудас, иргэн гэр бүлээ коронавирусуус сэргийлэх гарын авлагыг тараалаа.

Уулбаян:

ЕБСургуулийн математикийн багшид орон сууцны дэмжлэг үзүүлж 27550,0 мянган төгрөгийг мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гаргасан.

Аймгийн нөөцөөс 3450 ширхэг үнэгүй өвс, 2850 ширхэг өвсийг 4500 төгрөгөөр худалдан авч иргэдэд тараагаад байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:2020 оны 01 сарын 03-нд “Аймгийн аварга малчин”-ы 2 тодорхойлолтыг багийн аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт хүргүүлснээр дээрх 2 малчны шагнал дэмжигдсэн.

Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2018 оны 03 сарын 26 ны өдрийн дугаар А/22 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу “Мөнгөн унаганы эзэн” шалгаруулах шагналд 1 малчны материалыг бүрдүүлж, сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, холбогдох газарт хүргүүлсэн.

Мал эмнэлгийн нэгдсэн программд 2019 оны төлөвлөгөөт тарилгыг хувийн хэвшлийн малын эмч нараас авч нэгтгэн орууллаа.

Бух , бог малын хээлтүүлэгчийн тоогоор ээмэгний захиалга бух 113, хуц 1035, ухна 514 бүгд1662 хээлтүүлэгчээс бух 8, хуц 50, ухна 24 нийт 82 ээмэгний захиалга өгөөд байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт: Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус ажилтанг байгууллага бүр дээр томилж тушаал шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Орон тооны бус ажилтанг урамшуулах хэлбэрийг хүүхдийн цэцэрлэг ханган ажилласан ба 2020 оноос томилсон албан хаагч бүрт байгууллага бүр өөрийн төсөв багтаан сар бүр олгож байхаар тохиролцлоо.

Ажил хайгч иргэнээр бүртгэгдсэн 170 гаруй иргэнээс 15 иргэний мэдээллийг шинэчлэхэд эмэгтэй-6, шинээр 3 иргэнийг ажил хайгчаар бүртгэхэд эмэгтэй-1 бүртгэгдлээ.Шинэ ажлын байранд-4 эмэгтэй-1,түр ажлын байранд-6 эмэгтэй-3 иргэн зуучлагдсан.

СДДаатгалд 78 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулан 9886,3 мян төгрөгийн шимтгэл , Эрүүл мэндийн даатгалд 83 даатгуулагчийг даатгаж 3642,9 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Боловсрол: Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээллийг тухай бүр багш, ажилчид, сурагчид, эцэг эхчүүдэд мэдээлэхээс гадна сурагчид, эцэг эх асран хамгаалагчдад анги удирдсан багш нарт ТВ хичээлийн хуваарийг цахимаар танилцуулж, ТВ хичээлээ хэрхэн үзэж судалж байгаа талаар мэдээллийг авч байна.

Хүүхдийн цэцэрлэг 2 сарын 21 байдлаар нийт 155 хүүхдээс Теле хичээл үзсэн: 140 буюу нийт хүүхдийн 90,3%. Үзээгүй: 12/ холбогдож чадахгүй байгаа учраас үзээгүйгээр авсан болно.Үзэх боломжгүй: 3 хүүхэд

Хууль, эрх зүйн чиглэлээр: Хүүхдийн тоогоор ажилласан жил нэмж байгаатай холбогдуулан 46 хүнд нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаар мэдээлэл хийлээ.

Гэмт хэрэг, хэв журмын зөрчлийг түргэн шуурхай илрүүлэх, цагдаагийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Приус 20 авто машиныгавч өгсөн.

Архидан согтуурахын эсрэг хийх ухуулга сурталчилгааг тогтмолжиж сарын бүрийн 1,11,21-ний өдрүүдэд архи согтууруулах ундаа худалдахгүй байх шийдвэрийг гаргаж үүний үр дүнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 60 хувиар буурч нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 23 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Халзан:

Боловсрол: Сум, сургуулийн болон анги бүлгийн цахим хуудсаар дамжуулан сурагчид болон эцэг эхчүүдийг цаг үеийн мэдээ мэдээллээр ханган ажиллалаа. Сургуулийн дотоод группээр багш, ажилчдад ажлын чиглэл, зөвлөмж, мэдээллийг цаг тухайд нь хүргэж, цахим хичээл үзэж байгаа байдалд хяналт тавьж байна. Сургуулийн дотоод группээр АУБ нар цахим хичээл үзэж байгаа сурагчдын зургийг оруулахаас гадна сурагчдад зөвлөмж зөвлөгөө өгөн эргэх холбоотой ажиллаж байна. Цахим хичээл үзэж байгаа сурагчдын тоо 123 буюу нийт сурагчдын 64.7% нь байна. Сумаас алслагдсан сүлжээ байхгүй газарт өвөлжиж байгаа сурагчдын ар гэр, эцэг эхтэй холбоо барьж чадахгүйн улмаас мэдээлэл солилцож чадахгүй байна. Эдгээр сурагчдад бусдаар дамжуулан даалгавар өгч явуулсан байгаа.

Теле хичээлтэй холбогдуулан бүлгийн багш нар хүүхдүүдийг хичээлээ хийхэд нь хяналт тавьж, зургаар баталгаажуулан авч , мөн гэрийн даалгавар өгөн хуваарийн дагуу гэрээр нь очиж шалгаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: 2020 онд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 5 ажлын саналыг дээд газарт хүргүүлсэн. Ажил хайгч 5 иргэний мэдээллийг сэргээсэн., ажил зуучлалаар 5 иргэнийг хөдөлмөрийн мэдээллийн санд бүртгэсэн.

Мал эмнэлгийн чиглэлээр: Мал эмнэлгийн тасгаас Хүнсний дэлгүүрүүдээр явж Шинэ корона вирустэй холбоотойгоор зарим хүнсний бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байх талаар зөвлөмж тараан ажиллалаа.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Арьс, шир ноосны урамшуулал аваагүй 15 иргэдийн овог нэр, регистр, дансны дугаарын залруулга хийж явууллаа.

2020 оны 02 дугаар сарын 13-наас сумын нөөцийн өвсийг өвөлжилтийн байдал хүндэрсэн шаардлагатай малчдад тарааж байна.

ЖДҮйлдвэр, Сум хөгжүүлэх сангийн чиглэлээр: 2020 оны 02-р сарын 20-ны байдлаар нийт 18 зээлдэгч байгаагаас 2020 оны 02 сарын зээлийн эргэн төлөлтийн орлого 5 хүнээс 1,508,000 мянган төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нийт 18 зээлдэгч нартай утсаар ярин эргэн төлөлтөнд төлөх тал дээр анхаарч ажиллаж байна.

Байгаль орчны чиглэлээр: Сар шинийн баярыг тохиолдуулан айл өрхийн ахуйн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж нийт 50 өрхийн 20 тн хогийг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэв.

Уул овоогоо бохирдуулахгүй цэвэрхэн шинэлцгээе уриалгыг Сумын фэйсбүүк хуудсанд тавьж байршуулав.

БОАЖЯ-наас гаргасан шторкыг Сумын фэйсбүүк групп-д тавьж олон нийтийн хүртээл болгов.

Эрдэнэцагаан:

ИТХ, Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны хүрээнд: БНХАУ-д дэгдээд байгаа шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, сар шинийн баярыг тэмдэглэхгүй байх талаар зөвлөмжийг ард иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж ажилласан.

Сар шинийн баярыг өрх бүр гэртээ цомхон тэмдэглэх болсонтой холбогдуулан Цагдаагийн тасаг болон Албан байгууллагуудтай хамтран хөдөлгөөнт эргүүлийг зохион байгуулж нийт 4 аж ахуй нэгж, 6 албан байгууллага эргүүл хийж ажилласан бөгөөд мөн Сумын засаг даргын захирамжаар Засаг даргын тамгын газраас 33 хүний бүрэлдэхүүнтэй хариуцлагатай жижүүрийг томилж Сар шинийн баярын өдрүүдэд албан байгууллагын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж 24 цагаар шуурхай жижүүр гаргаж Аймгийн шуурхай штаб болон Гал түймэр унтраах аврах 47-р ангид мэдээлж ажиллаж байна.

Соёлын төв: Олон нийтийн үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулан цахимаар “ханьтайгаа хамтдаа”, “номтой сэлфи” фото зургийн уралдаан, “монгол ёс дууг хэн сайн дуулах вэ” дууны тэмцээн зэргийг амжилттай зохион байгуулсан.